



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 104

Эрдэнэт

Ээлжит хуралдаан  
зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн Ээлжит VIII хуралдааныг 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Эрдэнэт хотод зарлан хуралдуулж, дараах асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай.

- 1.1.Тогтоолд өөрчлөлт оруулах тухай
- 1.2.Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлах тухай
- 1.3.Аялал жуулчлалыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр батлах тухай
- 1.4.Журам шинэчлэн батлах тухай
- 1.5.Зохион байгуулалтын асуудал хэлэлцүүлэх тухай

Хоёр.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит VIII хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

Гурав.Хуралдааны бэлтгэл хангаж хуралдуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга П.Пүрэвлхагвад даалгасугай.



ДАРГА  П.ПҮРЭВЛХАГВА